

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр, Мягмар гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 4
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 - 8
1.	<i>Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 4 гишүүн 2024.05.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	5 - 6
2.	<i>“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	6 - 8

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 06 дугаар сарын 04-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 01 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Өнөрболор;

Чөлөөтэй: Г.Амартүвшин, Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Ж.Батсуурь, С.Ганбаатар, Б.Жавхлан, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн.

Нэг.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 4 гишүүн 2024.05.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Захиргааны газрын дарга О.Энхбаяр, мөн компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт Н.Рэнцэнтогтох, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Захиргааны газрын дарга О.Энхбаяр, мөн компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт Н.Рэнцэнтогтох, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн шинэ төхөөрөмж ажиллахгүй байгаа учраас гар өргөж санал хураалт явуулъя гэсэн горимын саналыг гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасны дагуу зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шат нэгтгэн явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 7 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 12 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим
12 цаг 01 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Хавдисламын хавдисламын
Баделхан гишүүн, Хүрэлбаатарын
Булгантуяа гишүүн, Цэрэнпилийн
Даваасүрэн гишүүн, Лхагвын
Мөнхбаатар гишүүн, Салдангийн
Одонтуяа гишүүн, Бөхчулууны
Пүрэвдорж гишүүн, Шатарбалын
Раднаасэд гишүүн, Цэндийн Сандаг-Очир
гишүүн, Дуламдоржийн Тогтохсүрэн
гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн
Байнгын хороо буюу 2024 оны 06 сарын
04-ний өдрийн хуралдаан нээснийг
мэдэгдье. /алх цохив/

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. Төсвийн тогтолцоо байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай, Тогтоолд өөрчлөлт оруулах тухай, Цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр батлах тухай, “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл байна. Эцсийн хэлэлцүүлэг.

Хоёр. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Анхны хэлэлцүүлэг байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа орёе.

Нэг.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 4 гишүүн
2024.05.22-ны өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлбэ.

Та бүхэнд олонхын дэмжлэг авсан саналыг төсөл бичигт нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг бас тараасан байгаа.

Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар дараах Байнгын хорооноос гаргах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулчих уу? Ц.Сандаг-Очир гишүүн танилцуулъя.

Ингээд хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хоёр. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хоёрдугаарх нь, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ингээд Төсвийн тогтоолын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед гишүүдээс хууль хоорондын нийцлийг хангах, өрийн удирдлагыг боловсронгуй болгох үүднээс “Хууль батлагдсантай холбогдуулан арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан батлуулах нь зүйтэй гэсэн санал дэмжигдсэн байгаа.

Үүнтэй холбогдуулаад Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан Та бүхэнд тараасан.

Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төсвийн тогтоолын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

1/Монгол Улсын зээл, тусламжийн нэгдсэн бодлогын хүрээнд

төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн авсан зээл, тусламжийн мэдээлэлд шинжилгээ хийж Өрийн удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-д заасны тухай Засгийн газрын гадаад зээлийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

2/Өрийн удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хуулийн өрийн удирдлагын эрх зүйн зохицуулалтын үр дүнд дүн шинжилгээ хийж, улсын нийт гадаад өр, улсын салбар, төрийн нийт өр, Засгийн газрын өр, өрийн болон орон нутгийн өмчит хувьцаат компанийн өрийн хамрах хүрээ, нэршил, тодорхойлолт, хязгаарлалтыг шинэчлэн боловсруулах;

3/Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн, хэрэгжиж байгаа төслүүдийн үр дүн, үр ашигт дүн шинжилгээ хийх, төслүүдийн хүрээнд үүссэн хөрөнгийн өмчлөл, эргэн төлөлтийн харилцааг тодорхой болгох;

4/Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлж, үе шаттайгаар хөгжүүлэх;

5/Зээлийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор гадаад зээлийн хөрөнгөөр зөвлөх үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал зэрэг урсгал зарлагыг санхүүжүүлэхгүй байх чиглэлийг цаашид баримтлах;

6/Засгийн газраас гадаад зээлийн гэрээ байгуулахдаа бодит эдийн засгийг дэмжсэн байх, үр ашигтай байх, дунд хугацааны хөгжлийн бодлого, улсын хөгжлийн хэмжээний төлөвлөгөөний баримт бичигт тусгасан байх шалгуурыг баримтлах;

7/Гадаад өр, улсын салбарын төрийн өрийн болон олон улсын нэгдсэн бүртгэл, стандарт, аргачлалыг нэвтрүүлж, холбогдох дэд бүтэц, мэдээллийн системийг сайжруулах;

2.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийг шинэчлэн баталсантай холбогдуулан “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 83 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд даалгасугай

4.Энэ тогтоолыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасны дагуу зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шат нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулья.

Гишүүд санал хураалт. Эхнийх тест санал хураалт явуулаадахъя. Шинэ төхөөрөмж байгаа учраас. Хуруугаа

хийгээд аваад хоёр кноп гарч ирэхээр дарна. Туршилтын санал хураалт. /алх цохив/

Энэ болохгүй байна. Дахиад туршилтынхыг хийгээдэхье. Байхгүй байна. Та хурлын үндсэн гишүүн байна. Санал хураалтад оролцох боломжгүй гэж байна.

Горимын санал гаргачих уу?
Горимын санал гаргачихъя.

Тэгээд төхөөрөмж ажиллах боломжгүй байгаад байгаа учраас нэг ч гишүүн юу байгаа учраас горимын санал гаргаж санал хураалтыг илээр буюу гараар санал хураалт явуулъя гэсэн санал гаргая.

Нийт 10 гишүүн, санал хураалтад оролцсоноос Х.Булгантуяа гишүүн.

60.0 хувиар дэмжигдлээ.

Ингээд санал хураалт дэмжигдсэн тул саяын уншсан саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя.

Ингээд 60.0 хувиар дэмжигдлээ.

“Хууль баталсантай холбогдуулан арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан дүгнэлтийг миний бие танилцуулчихъя.

“Хууль баталсантай холбогдуулан арга хэмжээний тухай” Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа.

Хуралдаан 7 минут үргэлжилж, 12 цаг 08 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД